



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын 2018 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/111/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь аймаг, Сайншанд сум
2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 99092469 Цахим хаяг:
Аудитын менежер: Э.Энхцэцэг
Утас: 90077079 Цахим хаяг:
Аудитор: Г.Энхтөр
Утас: 96441690 Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.
Дорноговь аймгийн Төрийн аудитын газар, Сайншанд сум, Орон нутгийн өмчийн 3 дугаар байр

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	11



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2019.02.26 № 1-6/199

танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Хүндэтгэн
Хүндэтгэн
Хүндэтгэн
Хүндэтгэн

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч. АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг хурлын нарийн бичгийн дарга С.Энхтуяад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 21-нээс 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар хариуцаж хэрэгжүүлэв.

Эрдэнэ сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 2 дугаар сарын 21-ний өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Эрдэнэ сумын ИТХурал нь Эдийн засаг нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
- Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын туха хууль *

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого холбогдох стандарт, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Эрдэнэ сумын ИТХурал санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн Acolous" програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 0.2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвийн дагуу зардлыг санхүүжүүлж байгаа тул үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс материаллаг байдлын түвшинг тогтоосонтой холбоотой юм.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын 2018 оны Нийт зардал 52,490.6 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 105.73 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 0.2 хувиар тооцсон нь нэг удаагийн ажил гүйлгээний дүнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	2,620.60	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	1	2,620.60	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулсан бөгөөд бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухао асуудал гараагүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 48,542.5 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 48,542.5 мянган төгрөг буюу 100 хувьтай байгаа нь төсвийн хэтрэлт, хэмнэлт гараагүйгээс шалтгаалжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Эрдэнэ сумын ИТХурал Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар буюу өмнөх аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ИТХурлын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-г нэр төрөл , үнийн дүнгээр тайлагнаагүй нийт дүнгээр гаргасан байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-г нэр төрөл , үнийн дүнгээр тайлагнаагүй нийт дүнгээр гаргасан байна.

Энэ нь үнэн зөв байх , эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан заавар тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Бараа материалын тайланг нэр төрлөөр гаргахгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Бараа материалын тайлан /НХМаягтБМ-9/-г Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан зааврын дагуу хийх , бараа материалд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Төгрөгөөр

	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,418,535.00	2,852,948.35
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ		-
8	Банкинд байгаа бэлэн мөнгө		-
9	Төгрөг		-
10	Төрийн сангийн харилцах		-
27	АВЛАГА		-
34	Бусад авлага	70,500.00	232,353.35
35	Байгууллагаас авах авлага	70,500.00	232,353.35
60	БАРАА МАТЕРИАЛ	70,500.00	232,353.35
66	Хангамжийн материал	2,348,035.00	2,620,595.00
67	Бичиг хэргийн материал	2,348,035.00	2,620,595.00
68	Аж ахуйн материал	240,235.00	173,195.00
73	Бусад хангамжийн материал	1,077,000.00	1,426,600.00
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,030,800.00	1,020,800.00
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,626,548.78	3,383,954.93
108	Биет хөрөнгө	4,626,548.78	3,383,954.93
111	Авто тээврийн хэрэгсэл	4,406,548.82	3,163,954.97
112	Хуримтлагдсан элэгдэл	980,000.00	-
113	Машин, тоног төхөөрөмж	(789,444.38)	-
114	Хуримтлагдсан элэгдэл	6,790,860.00	5,496,360.00
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	(4,556,032.85)	(4,672,096.87)
116	Хуримтлагдсан элэгдэл	2,958,550.27	3,598,550.27
125	Номын фонд	(1,031,384.22)	(1,312,858.43)
126	Биет бус хөрөнгө	54,000.00	54,000.00
127	Програм хангамж	219,999.96	219,999.96
128	Хасагдуулга	330,000.00	330,000.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	(110,000.04)	(110,000.04)
138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	7,045,083.78	6,236,903.28
139	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	219,768.00	-
164	Өглөг	219,768.00	-
165	Ажиллагчидтай холбогдсон өглөг	219,768.00	-
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	6,825,315.78	6,236,903.28
215	Засгийн газрын хувь оролцоо	6,825,315.78	6,236,903.28
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГ Сан/ орон нутгийн сан	3,061,355.24	3,061,355.24
218	-Хувийн	3,061,355.24	3,061,355.24
223	Хуримтлагдсан үр дүн	3,746,710.97	3,158,298.47
224	Өмнөх үеийн үр дүн	3,746,710.97	3,746,710.97
225	Тайлант үеийн үр дүн		(588,412.50)
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	17,249.57	17,249.57
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	7,045,083.78	6,236,903.28

4417144353
ЕЮА0056 9825707

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	47,518,700.00	52,242,500.00
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	47,518,700.00	52,242,500.00
112	Улсын төвлөрсөн төсвөөс	47,518,700.00	48,542,500.00
113	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	47,518,700.00	48,542,500.00
122	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	3,700,000.00
125	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хө	-	700,000.00
126	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төс	-	3,000,000.00
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	48,009,272.02	52,490,627.95
148	УРСГАЛ ЗАРДАЛ	48,009,272.02	52,490,627.95
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,220,862.02	52,483,907.95
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	36,854,327.00	37,354,814.46
151	Цалин	36,854,327.00	37,354,814.46
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,016,320.00	4,000,064.19
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	2,604,741.00	2,812,458.86
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	378,843.00	331,791.00
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	320,634.00	57,824.65
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	74,419.00	72,541.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	637,683.00	725,448.68
170	Хангамж, бараа материалын зардал	1,854,880.00	2,536,740.00
171	Бичиг хэргийн материал	365,320.00	240,340.00
172	Тээвэр, шатахууны зардал	1,054,060.00	1,456,500.00
173	Шуудан холбоо интернетийн төлбөр	435,500.00	606,900.00
176	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	-	223,000.00
178	Бараа материал актасны зардал	-	10,000.00
190	Томилолт, зочны зардал	936,500.00	755,800.00
192	Дотоод томилолтын зардал	936,500.00	755,800.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,048,800.00	4,818,780.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,048,800.00	4,818,780.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	2,510,035.02	3,017,709.30
211	Хячээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	655,700.00	1,365,400.00
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,854,335.02	1,652,309.30
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	788,410.00	6,720.00
228	Бусад урсгал шилжүүлэг	766,000.00	-
236	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	766,000.00	-
237	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,410.00	-
240	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,410.00	-
242	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	6,720.00
245	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,720.00
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-I-II)	(490,572.02)	(248,127.95)
276	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	340,284.55
277	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	340,284.55
287	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	-	(340,284.55)
288	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(490,572.02)	(588,412.50)

4417144353
EЮА0056 9025707

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Төгрөгөөр


	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	47,518,700.00	52,242,500.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	47,518,700.00	52,242,500.00
111	Улсын төвлөрсөн төсвөөс	47,518,700.00	48,542,500.00
112	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	47,518,700.00	48,542,500.00
121	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	3,700,000.00
124	ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангиллагдаагүй нөөц хөрөнгөнөөс	-	700,000.00
125	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	-	3,000,000.00
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	46,582,710.00	51,492,500.00
148	УРСГАЛ ЗАРДАЛ	46,582,710.00	51,492,500.00
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,780,300.00	51,485,780.00
150	Цалин, халс болон нэмэгдэл урамшил	36,640,900.00	37,264,700.00
151	Үндсэн цалин	36,640,900.00	37,264,700.00
157	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	4,450,100.00	4,471,800.00
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	3,202,121.00	2,981,200.00
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	317,797.00	372,700.00
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	262,294.00	298,100.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	64,454.00	74,500.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	603,434.00	745,300.00
170	Хангамж, бараа материалын зардал	1,248,300.00	2,229,600.00
171	Бичиг хэрэг	191,500.00	190,200.00
172	Тээвэр, шатахуун	682,600.00	1,200,000.00
173	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	374,200.00	589,400.00
176	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	250,000.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	100,800.00	100,000.00
189	Урсгал засвар	100,800.00	100,000.00
190	Томиллолт, зочны зардал	936,500.00	755,800.00
192	Дотоод албан томиллолт	936,500.00	755,800.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,808,400.00	3,208,880.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,808,400.00	3,208,880.00
208	Бараа үйлчилгээний бусад зардал	595,300.00	3,455,000.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,140,000.00
210	Хичээл үйлдвэрлэлийн даллаг хийх	595,300.00	1,315,000.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	802,410.00	6,720.00
222	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	6,720.00
223	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	6,720.00
225	Бусад урсгал шилжүүлэг	780,000.00	-
233	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	780,000.00	-
234	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,410.00	-
237	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,410.00	-
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	935,990.00	750,000.00
251	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
261	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	935,990.00	750,000.00
262	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	935,990.00	750,000.00
263	Дотоод эх үүсвэрээр	935,990.00	750,000.00
275	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	935,990.00	750,000.00
278	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(935,990.00)	(750,000.00)
279	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

4417144353
 ЕОА0056 9025707

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
ДАНС				
2017 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	3,061,355.24	116,303.17	4,138,229.39	7,315,887.80
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			99,053.60	99,053.60
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,061,355.24	116,303.17	4,237,282.99	7,414,941.40
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн		(99,053.60)	-	(99,053.60)
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз		-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз		-	-	-
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/		-	(490,572.02)	(490,572.02)
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,061,355.24	17,249.57	3,746,710.97	6,825,315.78
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,061,355.24	17,249.57	3,746,710.97	6,825,315.78
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,061,355.24	17,249.57	3,746,710.97	6,825,315.78
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	(588,412.50)	(588,412.50)
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,061,355.24	17,249.57	3,158,298.47	6,236,903.28


 4417144353
 ЕЮА0056 9025707

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	(0.00)	0.00	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	48,542,500.00	48,542,500.00	-	100.00
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	48,542,500.00	48,542,500.00	-	100.00
4	Бараа, үйлчилгээний зардал	48,542,500.00	48,535,880.00	6,620.00	99.99
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	37,264,700.00	37,264,700.00	-	100.00
6	Үндсэн цалин	37,264,700.00	37,264,700.00	-	100.00
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,471,800.00	4,471,800.00	-	100.00
12	Тэтгэврийн даатгал	2,981,200.00	2,981,200.00	-	100.00
13	Тэтгэмжийн даатгал	372,700.00	372,700.00	-	100.00
14	ҮОМШӨ ний даатгал	298,100.00	298,100.00	-	100.00
15	Ажилгүйдлийн даатгал	74,500.00	74,500.00	-	100.00
16	Эрүүл мэндийн даатгал	745,300.00	745,300.00	-	100.00
22	Хангамж, бараа материалын зардал	2,980,900.00	2,979,600.00	1,300.00	99.96
23	Бичиг хэрэг	191,500.00	190,200.00	1,300.00	99.32
24	Тээвэр (шатахуун)	1,200,000.00	1,200,000.00	-	100.00
25	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	589,400.00	589,400.00	-	100.00
28	Бага үнэтэй, түргэн эзгдэх, аж ахуйн эд зүйлс	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
34	Эд хогшил худалдан авах	100,800.00	100,000.00	800.00	99.21
38	Урсгал засвар	100,800.00	100,000.00	800.00	99.21
39	Томилолт, зочны зардал	759,300.00	755,800.00	3,500.00	99.54
41	Дотоод албан томилолт	759,300.00	755,800.00	3,500.00	99.54
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,650,000.00	1,648,980.00	1,020.00	99.94
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,650,000.00	1,648,980.00	1,020.00	99.94
53	Бараа үйлчилгээний бусад зардал	1,315,000.00	1,315,000.00	-	100.00
55	Хичээл үйлдвэрлэлийн ладлага хийх	1,315,000.00	1,315,000.00	-	100.00
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	6,620.00	(6,620.00)	-
67	Засгийн газар хоорондын шилжүүлэг	-	6,620.00	(6,620.00)	-
68	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	6,620.00	(6,620.00)	-
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	48,542,500.00	48,542,500.00	-	100.00
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	48,542,500.00	48,542,500.00	-	100.00
99	Улсын төсвөөс санхүүжих	48,542,500.00	48,542,500.00	-	100.00
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	(0.00)	0.00	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
130	БАЙГ УУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	-	-	-	-
134	Удирдах ажилтан	-	-	-	-
135	Гүйцэтгэх ажилтан	-	-	-	-
136	Үйлчлэх ажилтан	-	-	-	-
138	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-
148	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-

4417144353
 ЕНОА0056 9025707

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЭСЭЛИЙН ДҮН	-	-	-	-
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	3,700,000.00	(3,700,000.00)	-
4	Бараа, үйлчилгээний зардал	-	3,700,000.00	(3,700,000.00)	-
43	Буслаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	3,699,900.00	(3,699,900.00)	-
44	Буслаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	1,559,900.00	(1,559,900.00)	-
53	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,559,900.00	*(1,559,900.00)	-
54	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,140,000.00	(2,140,000.00)	-
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	2,140,000.00	(2,140,000.00)	-
67	Засгийн газар хоорондын шилжүүлэг	-	100.00	(100.00)	-
68	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	100.00	(100.00)	-
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	100.00	(100.00)	-
120	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	3,700,000.00	(3,700,000.00)	-
123	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс зох	-	3,700,000.00	(3,700,000.00)	-
124	Доод шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захир	-	700,000.00	(700,000.00)	-
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	3,000,000.00	(3,000,000.00)	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	-	-	-	-
134	Удирдах ажилтан	-	-	-	-
135	Гүйцэтгэх ажилтан	-	-	-	-
136	Үйлчлэх ажилтан	-	-	-	-
138	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жослын дунджаар/	-	-	-	-
148	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-

4417144353
 ЕНСА0056 9025707